

МОНГОЛ ХЭЛНИЙ ХОРШОО ҮГ, ХЭЛЛЭГИЙН
СУДАЛГААНЫ АСУУДАЛД

Ж.Бат-Ирээдүй*,
Г.Ариунжаргал**

Түлхүүр үг: Монгол хэлний хоршоо үг, хоршоо хэллэг

Монгол хэлний дэлхийн бусад хэлнээс ялгарах өвөрмөц нэгэн үзэгдэл бол хорших ёс юм. Хорших ёс хэмээх нэгэн сонирхолтой үзэгдэлийг хоршоо үгийн хэмжээнд түлхүү судлаж байснаас хэллэг, хэлц, үгүүлбэр, эх, цогцолборын төвшинд тэр бүр судалсангүй.

Бидний энэ үгүүлэлд хорших ёсны хэвчээ хүрээнд хамаарах зөвхөн хоршоо үг, болон хэллэгийн талаар дурдах юм. Хоршоо үгийн хувьд бүтэц нь хэдийгээр хоёр зүйл хоршин нийлж бүтсэн гэдэг энгийн логиктой мэт боловч чухам яагаад хоршин хэрэглэдэг нь монгол хүний сэтгэлгээний өвөрмөц онцлогтой холбоотой гэж үзэлтэй. Энэ нь нүүдэлчин монголчуудын байгалийн ч бай, нийгмийн ч бай аливаа зүйлийг сондгойруулахгүй байх, тэгшлэх, тал алдахгүй байх, хүлээцтэй байх, зэрэг сэтгэлгээний өвөрмөц онцлогтой холбоотой гэж үзмээр. Судлаачид хоршоо үгийн утга сэтгэлгээний талаар анзаарч үгээ хэлсэн нь цөөнгүй. Тухайлбал, академич Б.Ринчен “сэтгэхүйн нарийн санаа байдлыг нэвтрүүлдэг маш уян хатан арга хэрэглүүр” бөгөөд “монгол хэлнээ хоршоо үг, хорших ямар нэг үг үхширтэл хэвшсэн байдалтай бус маш уян хатан байдалтай” [Б.Ринчен:1967:80,82], д-р Ж.Баянсан “... монгол хэлний зарим хоршоо үг нь монголчуудын сэтгэлгээний онцлогийг тусгасан, үндэстний соёлын хамсал утгатай байдгийг тусгайлан судалж тайлбарлах шаардлага тулгамдаж байгаа билээ. Хоршоо үг бол хэдийгээр бүтэц энгийн, хэлбэр цомхон боловч утга гүн, санаа дэлгэр байдаг. Гүн гүнзгий өргөн дэлгэр санааг хоёрхон үгээр бүтсэн хэлбэрээр илэрхийлнэ гэдэг бол хийсвэрлэх сэтгэхүйн чадвар, хэмнэх арга зарчим (эсопому)-ийн баримт гэж үзэх ёстой юм.” [Ж.Баянсан:2002:23] гэсэн бол судлаач Б.Бямбадорж “... хоршоо буюу хоршсон нийлмэл үг монгол хэлэнд маш арвин олдох бөгөөд цаашид ч тасралтгүй үүсэн бий болж үгийн санг баяжуулсаар байх бололтой. Учир нь, монгол хүн аливаа зүйлийг нэрлэн хэлэх бол заавал хос буюу хоршоо үгээр илэрхийлж байдаг өвөрмөц сэтгэлгээтэй холбоотой ажээ.” [Б.Бямбадорж:2006:63] хэмээн бичжээ.

Хоршоо үг гэх энэ нэр томъёоны талаар маргаан бараг байдаггүй. Гэвч хоршоо үгийг эрдэмтэд янз бүрээр нэрлэсэн тохиолдол бий, харин хорших хоёр, хос буюу хослох зэрэг үгийн хо

* Монгол Улсын Их Сургууль, Монгол Судлалын Хүрээлэн

** БНСУ-ын Данкүүкийн Их Сургууль

язгуур аль ч нэрэнд нь хадгалагдсаар байна. Тухайлбал ихэнхи эрдэмтэд “хоршоо үг” хэмээх нэр томъёог баримталсан бол харин судлаач Ч.Чимэгбаатар, “холбон бэлгэлсэн үг”, “хошоод үг”, судлаач Б.Бямбадорж, “хоршоо буюу хоршсон нийлмэл үг” судлаач д-р Д.Баттогтох, “үгийн хоршоо” хэмээн өөр өөрөөр нэрлэжээ.

Монгол хэлний хоршоо үгийг дотоод, гадаадын олон эрдэмтэд олон талаас их сайн судалсан. Үүнд Г.Д.Санжеев, Б.Ринчен, Ш.Лувсанвандан, Б.Рагчаа, Т.А.Бертагаев, Ш.Дондуков, П.Бямбасан, Б.Пүрэв-Очир, Б.Баттогтох, Ц.Өнөрбаян, М.Базаррагчаа, Ч.Чимэгбаатар, Д.Бадамдорж, Д.Баасанбат нарын зэрэг эрдэмтдийн бүтээлийг нягтлан үзэж, тоочиж болно. Мөн бусад төрөл болон төрөл бус хэлтэй харьцуулан, зэрэгцүүлэн судалж бичиж байгаа судлаачид ч бий. Судалгааны байдлаас үзвэл ихэнхи судлаачид хоршоо үгийн чөлөөт зэрэгцсэн холбоо, дотоод бүтэц, үгийн сангийн асуудал уу үгүүлбэрзүйн асуудал уу, түүний үүсвэр бүрэлдэхүүн ба хэл найруулгын бүрэлдэхүүн үүрэг зэрэг асуудалд анхаарлаа төвлөрүүлж иржээ. Харин өнөөдрийг хүртэл нэг сэдэвт зохиолын хүрээнд багцлан судласан судалгаа гараагүй байна. Бид “хоршоо үг гэдэг бол хэлзүйн бүтэц, утга судлалын үүднээс хоёр үг нийлж нэг амьтай болон тогтсон үгийн сангийн өвөрмөц нэгэн нэгж юм” хэмээн тодорхойлж байна. Хоршоо үгийн бүтцийг авч үзвэл ямар ч байсан бүтэцэд нь хоёр өөр элемент буюу А буюу В [А В] гэсэн элемент оролцож бүтнэ гэж үзэж байна.

Эрдэмтэн Б.Пүрэв-Очирын бичсэнээр “Үг хорших нь хэдийгээр өгүүлэгчийн бодит байдалд хандах хандлага, үнэлэмж, санаагаа дэлгэрүүлэх, эрчимжүүлж, чангаруулах, эсрэгцүүлэх, адилтгах, тодчилох, батлах, өргөжүүлэх, үе болон үгийн хэм хэмжээ, аялга тэргүүтнийг тэгшитгэх зэрэгтэй нягт уялдаатай, бас хэлэх өгүүлэхийн зуур ярианы урсгал дахь авианы зохицол, хослол, яруусал, түүнчлэн хоршоо үгийн эхний ба эцсийн үгээс үүдэж, аналогитор хоршин нийлэх ёстой ч холбоотой гэж хэлэх үндэстэй байна.” [Б.Пүрэв-Очир:2007:87] гэдэгтэй санал нэг байна.

Чухам ямар үгийг хоршоо үг хэмээн нэрлэх вэ гэдэг талаар олон янзын тодорхойлолт бий. Тодорхойлолтуудыг ажиглавал тухайн үзэгдэлийг чухам аль өнцгөөс харсан байна вэ гэдэг нь сонин байна. Тухайлбал академич Б.Ринчен “Манай хэлнээ үг утгын зүйл баялаг учир тийнхүү хошоод үг нийлэн, нэгэн хам утга бүхий үг болдгийг ... хоршоо үг хэмээн нэрлэдэг...” гэсэн бол эрдэмтэн М.Базаррагчаа, “Монгол хэлний хоршоо үг нь харилцан тэгш эрхтэй хоёр гишүүнээс бүтэх ба тэдгээр нь авиа сэлгэх, бүтээвэр салаалах замаар бүтэхийн зэрэгцээ ойролцоо ба эсрэг утгат өгүүлбэр, төрөл зүйлээр хоршсон гишүүлбэр ч хоршоо үгийг буй болгодог ажээ. Үүнээс үзвээс хоршоо үг нь нийлэхийн хамт салах, салахын хамт нийлэх гэсэн хоёр үндсэн аргаар үүсдэг буй. Хоршоо үг нь харилцан зэрэгцэх (координация) холбоонд тулгуурлах бөгөөд үг бүтээх нэг хэрэглүүр болдог. Иймээс монгол хэлний хоршоо үг нь үг бүтээх ёсны судлагдахуун болох боловч бүтээвэр өгүүлбэр хоёрын завсрын төвшиний нэгж болно.” [М.Базаррагчаа:1990:1] , эрдэмтэн Д.Бадамдорж, “Хоёр үгийг хэм тэгш хэлж, нэгэн үгийн утгаас дэлгэр утга илтгэж, хоршин хэрэглэх дархлаа тогтосон байна. Тухайлбал, тэнгэр хангай, үүд хоймор, залуу зандан. ... Хоршоо үг бол гагц монгол төрөл олон хэлнээ буй дархлаа ч гэж хэлж болно. [Д.Бадамдорж:-2007:18], судлаач Д.Баттогтох “...үгийн хоршоо нь ямагт хоёр үгийг адил сонгож, аль алины утга оролцсон, хос утгыг заасан үгс байдаг байна. ...Монгол хэлний хоршоо үг нь хэдийгээр хоёр үгийн хам нийлц мөн боловч холбоо үг шиг чөлөөт бус, байр харьцаа нь хэлц үг шиг тогтвортой ч шилжсэн хийсвэрлэсэн утгагүй бодит утгаараа ухагдах өвөрмөц холбоо болно.” [Д.Баттогтох: 2009:36х.], судлаач Б.Бямбадорж, “Нийлмэл үгийн бүтэц дэх нэгжүүд (хоёр үг) нь бие биеэ захирахгүй, харилцан тэгш эрхтэйгээр зэргэцэн холбогдож бүтсэн нийлмэл үгийг хоршоо буюу хоршсон нийлмэл үг гэнэ” [Б.Бямбадорж:2006:63] хэмээн тодорхойлжээ.

Хоршоо үгийн бүтцийг бүрэлдэхүүний утгыг ажиглаж тодорхойлсон эрдэмтэд олон бий. Тэдгээрийн дүгнэлт үнэлгээ нь үндсэндээ нэг санал дээр нэгддэг. Монгол хэлний хоршоо үгийг үгийн сан утгын талаас авч үзвэл бараг ихэнхи нь ойролцоо, удаах нь эсрэг утгатай үг хоршдог гэдэг дээр санал нэгтэй байдаг. Үүнд эрдэмтэн Б.Ринчен, П.Бямбасан, Б.Пүрэв-Очир, Д.Баттогтох, Б.Бямбадорж зэрэг эрдэмтэд өөрсдийн санаа оноог дэвшүүлсэн билээ. Тухайлбал, судлаач Б.Бямбадорж, "... хос хосоор өгүүлэх байдлыг нь авч үзвэл, 1 ойролцоо утгатай үгсээр, 2 эсрэг утгатай үгсээр, 3 холбогдол бүхий үгсээр, 4 дууриан хорших гэсэн ийм дөрвөн арга зарчмаар хоршоо үгийг бүтээдэг байна." [Б.Бямбадорж:2006:64] гэжээ.

Хоршоо үгийн эзлэх хувьд ойролцоо утгатай үг хорших нь [A ≈ B] зонхилох байрыг эзлэх бөгөөд монгол хэлэнд хамгийн их хэрэглээтэй болно. Тухайлбал, *ааг омог, ад зэтгэр, айраг цагаа, багаж зэвсэг, барлаг боол, битүү нууц, бохир балиар, гэм буруу, доог тохуу, дэлгүүр хоршоо, жаргал цэнгэл, завсар чөлөө, зөн совин, ижил дасал, инээд хөөр, лус савдаг, огших хөөрөх, оёор ёроол, ойр дөт, өө сэв, үзэсгэлэн гоо, үйл оёдол, харуусал гуниг, хүсэх мөрөөдөх, хээл хахууль, хээр хөдөө, шим шүүс, эе эв, зэрэг* болно. Ойролцоо хоршоо үгийг Б.Пүрэв-Очир "... тэдгээр үгсийн аль нэг нь буюу ихэвчлэн эхний үг нь утгын өргөлттэй болж, сүүлчийн үг нь өмнөх үгийнхээ утгыг тодруулах, эрчимжүүлэх, чангаруулах, тухайн үгийн олон утгаас аль нэгийг нь онцлон ялгаж тодруулах үүрэгтэй төдийгүй нэмэлт мэдээллийг агуулж байдаг нэгэн зүйл онцлогтой" [Б.Пүрэв-Очир:2007:91] гэжээ. Ойролцоо утгатай хоршоо үгийг утга зохиолын баримтаас арвин олж болох бөгөөд тухайлбал, "Арван хэдэн насныхаа ааг омогоор хөтлөгдчихсөн явна." (*Р.Чойном*), "Та нар хорин мөнгө өг, би аарууд хурууд өгье." (*Б.Ринчен, "Үүрийн туяа"*), "Ийм битүү нууц хүнийг элдэв таавар хардалт дагалдаж мөшгөж байдаг нь ёс." (*С.Пүрэв, "Шөнийн талд одод амгалан"*), "Гол мөрөн ширүүн боловч эргээ дагаж урсдаг.", "Залуу бага насны минь заяа ерөөл яав?", (*Д.Нацагдорж, "Учиртай гурван толгой"*), *гэх мэт*

Эсрэг утгатай үг хорших нь [A ≠ B] хэмжээгээрээ ойролцоо утгатай үг хоршихын дараа орох бөгөөд тухайлбал *аз эз, босох суух, гадагш дотогш, дээгүүр доогуур, дэвсгэр хучлага, жаргал зовлон, зөв буруу, ижил буруу, ийм тийм, ил далд, илүү дутуу, ирэх буцах, наагуур цаагуур, орох гарах, өндөр нам, өрнө дорно, сүр сүлд, урагш хойш, урт богино, уруу өөд, үхэх үлдэх, хаа гуя, хар цагаан, хатгуур хутгуур, хойш урагш, элбэг дутуу, зэрэг өргөн хэрэглээтэй билээ. Эсрэг утгатай үгийн хоршоог проф. Б.Пүрэв-Очир "...өгүүлэмжийн утга санаа, үүрэг мэдээллийн орчноос хамааран, нэг бол олны утга илтгэх, эсвэл үйлийг дахин давтан үйлдэх байдлын утга, аль эсвэл утгын хоёр туйлын эсрэгцлээс саармагшсан гурав дахь утга ухагдахууныг илтгэдэг..." [Б.Пүрэв-Очир:2007:91] гэж тайлбарласан байна. Утга зохиолын баримтаар мөшгөн үзвэл, "Ил далд хэчнээн ч ан хийж, хэчнээнийг нь бас хот хүрээ рүү гүйлгэж, атигар биед томдсон ширэн түрийвчээ дүүргэж явсныг бурхан л мэдэх сан байх." (*Д.Гармаа, "Чонын үүр"*), "Бэр хүргэх бэлэгтэй, бялхаж халгих хуримтай, дэр нийлүүлэх жинтүүтэй, дээгүүр доогуур хүслэнтэй." (*Б.Нацагдорж, "Учиртай гурван толгой"*), "Хүлэг морьдын туурай өрнө дорныг цөмлөж хөл нүцгэн хорвоо халуун нурам гишгэсэн юм." (*Д.Пүрэвдорж, "Чингис"*) гэх мэт арвин буй.*

Монгол хэлний хоршоо үгийн бүрэлдэхүүнд авиа дуурайх болон дүрслэх үг хорших үзэгдэл тодорхой байр эзлэнэ. Авиа дуурайх үгийн хоршоо нь *жив жув, жиг жуг, жин жан, налчиг балчиг, пал пул, пий най, пэд пад, сүр сар, таль туль, тар няр, тар тур, ээн уун, дүрслэх үг хорших нь: жирэв зурав, найтаг тайтаг, өм цөм, там тум, тан ян,*

Монгол хэлний хоршоо үгийн бүрэлдэхүүнд бас нэгэн чухал байр эзлэх хоршоо бол толгой үгээ даган хорших маягын хоршоо юм. Жишээлбэл: *аахар шаахар, бага сага, гол мол, кино мино, мах зах, оймс моймс, сандал мандал, сохор мохор, төлөг мөлөг, хурал мурал, хүүхэн мүүхэн, элбэг дэлбэг, бээжин мээжин* гэх мэт. Ийм жишээг утга зохиолын баримтаас арвин олж болно. Гэтэл энийг зарим эрдэмтэд "...язгуурыг нь эс өөрчилсөн авиа зүйн үндэстэй

давталт” [Б.Пүрэв-Очир:1998:93] харин хоршилт биш гэж үзэж байна. Ийм хоршоогийн үр дүнд шинэ үг, нэрлэлт, утга үүсэхгүй бөгөөд үгийн сангийн үндсэн утгаа хадгалж тооны болон үл ойшоох, үл таашаах утга илэрдэг гэж үздэг. Харин “давталт бол хоршоо үг, хоршоо зэрэгцлээс утга, үүрэг, хэв шинжээрээ ялгаатай хэл, хэлэхүйн учир холбогдолтой өөр үзэгдэл мөн” [Б.Пүрэв-Очир:1998:110] гэдэгтэй санаа нийлж байгаа боловч дээрх хэв маягын зэрэгцэлийг хоршоо үг гэж үзэхээс өөр аргагүй. Ер нь давтан хорших гэдэг ойлголт байж болохгүй бөгөөд нэг бол хорших, эс бөгөөд давтах байхаас өөр аргагүй. Учир нь хорших гэдэг ойлголтод хоёр өөр элемент [АВ] оролцож байгаа, харин давтах үгэнд хоёр ижил элемент [АА] оролцож байгаа гэж үзэж болох юм.

Удаах нь **ижил язгууртай үг хорших**. Тухайлбал, *ааль ааш, айл аймаг, амар амгалан, байр байдал, бүлээн бүгээн, ган гачиг, гинших гийнах, гоёх гоодох, гэрэл гэгээ, даавуу даалинба, дарга даамал, зав зай, зайдан зайгуул, захиа зангаа, мах мариа, мөрдөх мөшгөх, мэлтэлзэх мэлмэрэх, намилзах намирах, нутаг нуга* гэх мэт. Үүнийг манай судлаачид хүлээн зөвшөөрсөн. Өөр нэг хоршоо үгийн цөөн боловч байгаа хэлбэр бол **авиа сэлгэх хорших, дэгэн догон, жин жан** зэрэг үгс юм.

Харин эрдэмтэн Б.Пүрэв-Очир, “Монгол хэлний хоршоо үгийн бүрэлдүүлбэр нь нэн тогтвортой байдлаар хэвшиж үгийн сангийн бэлэн нэрлэлт, нэр томъёоны шинжтэй болсон байхад зарим хоршоо үгийн бүрэлдүүлбэрийн байр тогтворгүй, хөдлөнгө шинжтэй байгааг тэмдэглэсэн боловч хоршоо үгийн бүрэлдүүлбэрийн утгын нэгдэл, тогтвортой ба тогтворгүйн учир холбогдлыг нухацтай тайлбарласан зүйл ховор байна” [[Б.Пүрэв-Очир:2007:86] хэмээн шүүмжилсэн билээ. Хэлц хоршоо үгийн тухайд проф. М.Базаррагчаа, “Монгол хэлний хоршоо үгийг түүний гишүүдийн утга хэлбэрийн нэгдлээс шалтгаалан тогтвортой, тогтворгүй хэмээн ангилж болно. Жишээ нь, *ана мана, ундуй сундуй, айман уйман* гэхэд хоршсон гишүүний аль нэг нь дангаар хэрэглэгдэхгүй. Үүнийг бүрэн ижилшсэн гэж болох ба үүх түүх, хүүхэд шуухад, ой той гэхчлэн хоёр гишүүний нэг нь бие дааж хэрэглэгдэх үгүй тул бүрэн бус ижилссэн хоршоо үг гэж ялгаж болно.” [М.Базаррагчаа:1993:4] гэжээ. Монгол хэлний хоршоо үгийн утгыг нарийн ажиглаж үзвэл өнгөн талаасаа хоёр үг нийлээд энгийн хоршоо мэт боловч гүн бүтэц утга талаас харваас хэлц хоршоо үг гэж хэлж болохоор үг олон байна.

Хоршоо хэллэг. Монгол хэлэнд дан хоршоо үгээс гадна хоршоо хэллэг гэж буй үүнийг судлаачид тэр болгон дурдаж судлаагүй байна. Хоршоо хэллэгийн бүтэц нь холбоо үгээс үгүүлбэрийн төвшинд байх боломжтой зүйл. Тухайлбал монгол хэлэнд *дааганд хөнгөн, даавуунд арвитай; дөрвөн зүг, найман зовхис; зүс үзээгүй, нүд таниагүй; зүрх хөөрүү амьсгаа дээр; исгэл халуун цустай, идэр залуу настай; муу хүний нойр, мулгуу хүний шүлс; нүдэн балай, чихэн дүлий; оргүй худал, мөргүй сохор; өдрийн бодол, шөнийн зүүд; нам нийлж сэм сүлбэлдэх; ноён урвамхай, нохой шарвамхай; нойр шингэрэх, бие хөнгөрөх; өөх ч биш, булчирхай ч биш; саруул ухаантай, эрүүл биетэй; сарын газрыг өдрөөр, өдрийн газрыг цагаар; сувдаг сэтгэлтэй, суйлдаг гартай; түм түжигнэж, бум бужигнах; сэлэм гялс, толгой бөндгөс; сэтэрхий зүү, сиймхий самбаа; унах морьгүй, унагаах ямаагүй; уранхай дээлтэй, туранхай царайтай; үг олох, үхэр холдох; үйлээ үзэж, тамаа цайх; хавирга газрыг халцартал, өвдөг газрыг өлтөртөл; хар ч гэсэн хааны хишиг, бор ч гэсэн богдын хишиг; ховдог сэтгэл, хомхой санаа; хөдөө хөхөрч, гадаа гандах; хэвэл нэгтэй, хэлхээ бэхтэй; элэг дэвтээх, энгэрт асах; энгэр зөрөх, дэр нийлэх; энгэрт чинь өргөс, элгэнд чинь бэтэг; гэх мэт маш арвин баялаг байдаг. Үүнийг утга зохиолын хэлний найруулгаас нуттай олныг олж болно. Тухайлбал, Албандаа зүтгүүлэх, атгандаа мөлхүүлэх, “Базар шилд шилэрч явсан нь үнэн болов чоно болоогүй хүн хэвээр байгаа нь үнэн. Ингэхлээр түүнийг би **албандаа зүтгүүлж, атгандаа мөлхүүлэх** ёстой хэмээн зүүн гар адуучны ноён Базартай ойртож түншилсэн түүхээ цагаатгадаг байжээ.” (Д.Маам, “Газар шороо”), Бие тэргүүтэй, дээл захтай “Бодончар, Буха хатаги ахын хойноос даган хатирч үгүүлрүүн, Ах аа, ах аа **бие тэргүүтэй, дээл захтай** нь*

сайн гэвэл ах нь тэр үгийг хайхарсангүй.” (“Монголын нууц товчоон, 33 дугаар зүйл”), гарыг нь барьж, хөлийг нь хүлэх “Хар хятадын Өвөгжин ноёхон үгүүлрүүн гарыг нь барьж, хөлийг нь хүлж өгье гэжээ.” (“Монголын нууц товчоон, 166 дугаар зүйл”), гон бие, гозон толгой “Дамбий хэдэн жил гон бие, гозон толгой явав.” (Б.Бааст), доороо суурьтай, дотроо бодолтой “Үүнийг мэдсэн юм шиг хүүгийн засуул ‘аандаа ах чинь заагаад өгнө өө доороо суурьтай, дотроо бодолтой үзнэ шүү’ гэж үг заана.” (Д.Цэдэв, “Улаан хамбан зодог буюу тавын даваа”), Зээгийн зүсээр, охины өнгөөр: “Чингис хаан үгүүлрүүн, Эдний хонгирад эртнээс эхлэн одоо хүртэл зээгийн зүсээр, охидын өнгөөр явна гэх тэдний дууллыг дурдан сануулбал дуртайяа элсэн дагах биз. Хэрэв эсэргүүцвэл байлдаж эзлэгтүн гэж Жорчидайгаар толгойлуулан урууд иргэнийг илгээвэл хонгирад нар түүнд элсэн оржээ.” (“Монголын нууц товчооны 175 дугаар зүйл”), идэх гээд эрхийгээ, долоох гээд долоовроо “Харин баахан халмаг буцаж ирээд чихэр хийж шар тосонд зуурсан балингийн амттай гурил авчирч дамшиг минь идэх гээд эрхийгээ, долоох гээд долоовроо идчих вэ дээ гээд хотынхондоо өгдөг заншилтай билээ.” (Ч.Лодойдамба, “Тунгалаг Тамир”), унасан газар, угаасан ус “Унасан газар, угаасан ус гэдэг үрсээ аргамжиж, шувуудаа хоргоодог хойно энэ хүмүүсийн түмэн зөв байлаа.” (С.Пүрэв, “Наран шарлагын газар”), үүрийн цолмон, үдшийн гялаан “Манайхан ч яахав Цэ вангийн охин, цэргийн дарга Лутаа хоёр ч ёстой үүрийн цолмон, үдшийн гялаан хоёр шиг хоёр амьтан нийлэх нь гэлцэв.” (Б.Бааст, “Хаш аяга”), хүний нутаг, гүний газар “Ингэж дүү нь ахынхаа ганц морийг авч хүний нутаг, гүний газар гахай явган болгожээ.” (Ч.Лодойдамба, “Тунгалаг Тамир”), хээрээр гэр хийх, хэцээр дэр хийх “Өвгөн намрын хэдэн сард хээрээр гэр, хэцээр дэр хийж явахдаа малын хүмүүстэй уулзаж хүүгийнхээ сургийг тандана.” (Б.Даариймаа, “Шар хондны намаржаа”),

Эдгээр хоршоо хэллэгийн утгын холбогдол дотоод бүтцийг авч үзвэл мөн дан хоршоо үгтэй адил ихэнхи нь ойролцоо бас эсрэг утгатай байж болдог. Жишээлбэл ойролцоо утгатай хэллэгийн хувьд [A ≈ B] загвартай бөгөөд жишээ нь “албандаа зүтгүүлэх, атгандаа мөлхүүлэх”, “алд биендээ торготой, арван хуруундаа алттай”, “ахыг нь алж, дүүг нь дүүжлэх”, “бие тэргүүтэй, дээл захтай”, “бууны ам, жадны үзүүр”, “бүлүүргүй далай, бүсгүй орчлон”, “хөхөө өвлийн хүйтэн, хөр цасны хайруу”, “хээрээр гэр хийх, хэцээр дэр хийх”, “ажил хийх, хөлс урсгах”, “ган дөрөө сэтрэх, ганц бие гандах”, “гон бие, гозон толгой”, “гэгээн цагаан өдөр, гэрэлтэй шар нар”, эсрэг утгатай хэллэгийн хувьд [A ≠ B] загвартай бөгөөд нь “хөх тэнгэрийн дор, хөвд өвсний дээр”, “хундага тавилгүй архи уух, хутга тавилгүй мах идэх”, “цагаан идээнд цацах, хар идээнд хахах”, нэгээс нөгөө нь нөхцөн шалтгаацах утгатай хэллэг нь [A → B] загвартай бөгөөд, жишээ нь, “арав таван адуу хөөж, амьтан хүн үймүүлэх”, “хур бууж, цэцэг дэлгэрэх”, “эрийг нас, уулыг цас”, “гэрээс холдох, гэдэс дундлах” гэх мэт байна.

Хоршоо үгийн дотоод утгын судалгааг олон эрдэмтэн сонирхож судалсан. Тухайлбал, академич Б.Ринчений 1967 онд хэвлүүлсэн “Монгол бичгин хэлний зүй” дөтгөөр дэвтэр буюу “Өгүүлбэрзүй” гэдэг бүтээл нь үндсэндээ монгол хэлний хоршоо үгийг бараг дангаар нь авч үзсэн зохиол юм. М.Базаррагчаа, “Монгол хэлний хоршоо үг нь үг бүтэх ёсны судлагдахуун болох бөгөөд бүтээвэр өгүүлбэр хоёрын завсарын төвшиний нэгж болно. Бүтээвэр нь авиа сэлгэх ёстой амин холбоотой юм. Бас хоршоо үг нь үгийн утга салаалахтай холбогдох тул хэвшмэл үг (идиома)-тэй адил байх нь буй. М.Базаррагчаа:1990:1, хэмээн хоршоо үгийн утгыг хэлшинжлэлийн бусад салбартай холбон тайлбарласан.

Хоршоо үгийн хамгийн гол үүрэг нь монгол хэлний найруулгын гол барьцалдуулан батжуулан бэхжүүлэх материал болж өгөх явдал мөн гэж үзэлтэй. Ер нь хоршоо үгийн найруулгын үүргийн талаар олон эрдэмтэн олон талаас нь дуугарсан. Тухайлбал профессор Б.Пүрэв-Очир “... хоршоо үгс нь дүр дүрслэлийг тод томруун болгох, найруулгын өнгө

аясыг ялгамжааг илэрхийлэх, уран сайхны харшууллыг үзүүлэх, найруулга тэгшитгэх, шүлэг зохиолын айзам хэмжээг тохируулах найруулгын авианы хэрэглээүүрийн үүрэг гүйцэтгэх, толгой, сүүл холбоцыг оновчтой хийх, аху байдлыг орон цаг, тоо, чанарын талаас уран сайхнаар дүрслэн үзүүлэхэд маш чухаг хэрэглүүр ..." [Б.Пүрэв-Очир: 2008:106] болох тухай дурдсан бол профессор Ц.Сүхбаатар, "Монгол хэлний найруулгад хоршоо үг, хоршсон аливаа үг хэрэглэх нь монгол найруулгын сондгойруулахгүй зарчимд тун зохистой. Монгол найруулгын уламжлалд хоршоо үгийн тэгш хэмийг эрхэмлэж, илүүц үг үсэг нэмэхгүй, хасаж сондгойруулан хэлтийдүүлэхгүйг хичээж, энэ ёсыг найруулгын чухал шаардлага гэж хичээнгүйлэн мөрдөж иржээ." [Ц.Сүхбаатар:2009:299] хэмээн сондгойруулахгүйн зарчим чухал болохыг дурдсан бол БНСУ-ын эрдэмтэн бөлгөө Канг Шинь бээр, "... хоршоо үг, хэлц үгийн зөв хэрэглээ бүхий найруулгын үүрэг нь чихнээ чимэгт монгол хэлний яруу тунгалагийг улам төгөлдөржүүлж, түүний арвин баян, тансаг ариуныг улам мэдрүүлэх тул олон нитийн хэвлэл мэдээлэл, эх хэлний сургалтын агуулгад зайлшгүй тусгууштай зүйлийн нэг болж байна." [Канг Шинь] хэмээн бичиж байлаа. Монгол хэлний хоршоо дан гагц бичгийн хэлэнд бус аман хэлэнд ч арвин хэрэглэгддэгээрээ үгийн сангийн бусад нэгжээс их ялгаатай. Энэ тухай д-р Д.Баттогтох, "Монгол хэлний хоршоо үг аман ба бичгийн хэлэнд маш эртний үүсэл хэрэглээтэй, дан үгийн утгаас хавьгүй ерөнхий хийсвэр шинжтэй, үгийн сангийн бусад нэгжтэй ойролцоо ба эсрэг утгын харьцаанд орж чаддаг, найруулгын өвөрмөц үүрэгтэй." [Д.Баттогтох: 2009:12х.] гэжээ.

Хоршоо үг чухам шинэ утга үүсгэж байна уу аль эсвэл найруулгыг чимэх төдий үүрэг гүйцэтгэж байна уу гэдэг талаар судлаач Б.Бямбадорж "... эцэг эх зэрэг жинхэнэ нийлмэл үгийн шинжтэй цөөг үгийг эс тооцох аваас монгол хэлний хоршин зэргэцэж бүтсэн нийлмэл үг гэгч нь угтаа, монгол хүний холбон сэтгэхүйн өвөрмөц онцлогтой уялдан тухай тухайн нөхцөол тийнхүү хос хосоороо үүсэн хэрэглэгдэж буй болохоос, угсарсан нийлмэл үгийн адилаар яг хоёр үг нийлээд гурав дахь цоо шинэ нэрлэлтийн нэгжийг үүсгэж бүхий хэрэг хараахан биш..." [Б.Бямбадорж:2006:63] гэсэн бол д-р Д.Баасанбат "Ер нь хоршоо үгийн үүрэг нь нэмэлт мэдээллийг дамжуулах, өгүүлбэрийн утгыг өргөсгөх дэлгэрүүлэх, ерөнхий олон болон хам олны санааг гаргах, юм үзэгдлийг ерөнхийлөн бүлэглэж үгүүлэх, найруулгын өнгө аясыг тодорхой илрүүлэх, төсөөт буюу ойролцоо өгүүлбэрийг бүтээж, найруулга тэгшитгэх, шууд ба шууд бус нэрлэлтийн өгүүлбэрт онцолборыг илрүүлэх, тодруулах, ойролцоо ба эсрэг утгатай үгээр авианы байдлыг харгалзан мөр бадгийг ойртуулах, тэнцүүлэх, хайрцаглан эн зэрэгцүүлэх, тоочлого гаргах, толгой сүүл холбох, утга дүйх үгтэй нь солин найруулах өргөн боломжтой...", "... хэлний өвөрмөц нэгж болох, тоочин буюу давтан хэрэглэснээр ялангуяа яруу найрагт утгын тодорхой гүн гүнзгий, уран дурслэлийг бий болгох, боломжтойгоос гадна уран зохиолын найруулгад хоршоо үгийг бүр ч их хэрэглэдэг болох нь тодорхой байна." [Д.Баасанбат:2007:15] гэжээ.

Утга зохиолын төрөл бүрийн найруулгыг авч үзвэл ялангуяа уран зохиолын найруулгад хоршоо үг хэллэг маш арвин хэрэглээтэй байна. Харин албан бичгийн найруулгад ямар нэгэн хэмжээгээр зөвхөн зохистой газар л хэрэглэж байдаг байна.

Нэг зохиолын хоршоо үгийн судалгаа бас чухал. Ер нь монгол хэлний бусад үзэгдлийн хувьд нэг зохиол дээр дангаар нь авч үзэж байсан нь тэр болгон элбэг биш бөгөөд нэг зохиолын хоршоо үгийн судалгааг олон янзаар хийж байгаа нь түүний хэрэглээний хэр өргөн хүрээтэй болохыг харуулж байгаа нэг үзүүлэлт юм. Монголын уран зохиолын аль ч чиглэл нь хоршоо үгээр тун баялаг. Хоршоо үгийн толь бичиг хийх явцад энэ бүрэн ажиглагдаж байлаа. Гэхдээ хоршоо үг бол зориуд зохиолоо баяжуулж, ахиулах нэг арга биш бөгөөд харин зохиолын найруулга, хэлэх санааг гүнзгийрүүлэх зорилгоор зохистой газар нь зөв ашиглаж чадвал найруулгыг уран яруу тансаг болгох, уншигчид ойлгомжтой, хүртээмжтэй болгох үүрэгтэ байдаг. Хоршоо үгийг судлах явцад утга зохиолын олон баримтаас гадна зөвхөн нэг зохиолын

хоршоо үгийг судлах явдал бас сонирхолтой судалгаа байдаг билээ. Нэг зохиолын хоршоо үгийн судалгаа хэдийгээр цөөн боловч монгол хэлшинжлэлд хийгдсэн ажил билээ. Тухайлбал, профессор М.Базаррагчаа, Б.Ринчений “Сандо амбан” жүжиг, Лувсанданзаны “Алтан товч”, д-р Д.Баасанбат, “Хөх судар” романы хоршоо үг”-ийг түүвэрлэж тооцож, бие даасан ном хэвлүүлсэн байна. Профессор Б.Пүрэв-Очир, Ц.Дамдинсүрэнгийн зарим зохиолуудын онцлог хоршоо үгүүдийг онцгойлон судлаж тайлбарлаж эрдэм шинжилгээний үгүүллүүд бичсээр байна. Дан зохиолын хоршоо үгийн судалгаа хийснээр тухайн зохиолчийн ур чадвар, хэлний үзэгдлийг чадамгай хэрэглэсэн байдал, давтамж, хэрэглээний хэм хэмжээ зэрэг олон зүйл харагдах бөгөөд цаашид энэ чиглэлийн судалгааг дэлгэрүүлэн хөгжүүлж судлууштай.

Хоршоо үгийг толилсон туршлагыг авч үзвэл хоршоо үг нь ийнхүү хэлний бодит хэрэглээнд маш чухал байртай, яриа ба бичгийн хэлэнд өдөр тутам байнга хэрэглэгдэж байдаг учраас түүний хэрэглэх хэм хэмжээг тодорхойлох явдал хэл судлаачдын нэг чухал үүрэг юм. Хоршоо үгийг толиллон төрөл бүрийн толь бичиг гарын авлага хийх нь бичих найруулах, зохиох, болон бусад төрлийн зорилгоор ашиглах хүмүүст маш их ач холбогдолтой билээ. Монгол хэлний хоршоо үгийн талаар Ч.Чимэгбаатар, “Холбон бэлгэлсэн үгийн товч” (1996), Ж.Бат-Ирээдүй, “Монгол хэлний хоршоо үгийн товч толь бичиг” (2008), “Монгол хэлний хоршоо болон давтамж үг хэллэгийн сан” (2009), зэрэг хоршоо үгийн бие даасан том бага толь бичиг, гарын авлагууд хэвлүүлсэн билээ. Ч.Чимэгбаатарын тольд нийт 4000 орчим нэр хоршоо үг хам сэдэв, Ж.Бат-Ирээдүйн тольд давхардсан тоогоор хамгийн өргөн хэрэглээний 5000 орчим үг бүрэн жишээний хамт багтсан байна. Энд практик ач холбогдолын үүднээс уг хоршоо үгийг чухам ямар зохиолоос иш татсан тухай бүрэн мэдээлэл оруулсан. Мөн энэ толь бичиг тухайн нэг үгийн хоршоо үгийн үүр бараг бүрэнээрээ багтсанаараа өмнөх толь бичгүүдээс өвөрмөц юм. Жишээ нь амар гэдэг үгтэй холбоотой *амар амгалан, амар жамар, амар жаргал, амар жимэр, амар заяа, аман мэнд, амар тайван* гэдэг хоршоо үг, нэр гэдэг нэр үгтэй үүр уг утга гарвалаараа холбогдох *нэр гавьяа, нэр зар, нэр нүүр, нэр сүр, нэр төр, нэр цуу*, зэрэг үгс багтсан нь хоршоо үгийг элдэв төрлийн найруулгад хэрэглэх хүн ашиглахад тун амар болсон бөгөөд монгол хэлний хамгийн өргөн хэрэглэгддэг хоршоо үгс багтсанаараа бусад толь бичиг гарын авлагаас онцлогтой болсон.

Ийнхүү монгол хэлний хоршоо үг, хэллэгийн судалгааг дүгнэн үзвээс монгол хэлний үгийн сан, үгзүй, үгүүлбэр зүй, найруулгын судлалын заагт аль ч талаас нь судалж болох хоршоо үг хэмээх нэгэн сонин үзэгдлийг бүтэц, утга, найруулгын үүрэг талаас судалбал асар их нөөц байгаа бөгөөд цаашид бүхэл бүтэн нэгэнт сэдэвт ажлын хүрээнд олон талаас цэгцтэй судлах эзнээ хүлээж байгаа сэдэв гэдгийг цохон тэмдэглэмээр байна. Монгол хэлний хоршоо үг нь ямар ч байсан хоёр өөр бүрэлдүүлбэрээс бүтэх буюу [А ба В] гэсэн бүтэцтэй [голох шилэх, ирэх очих, нуруу туруу, тарга хүч] болохыг тодорхойлов. Энэ загварын дагуу авч үзвэл А ба А гэсэн бүтэц бүхий давтамж нь [айл айл, хүн хүн гм] хоршоо үг биш гэж үзэх үндэстэй.

Хорших ёсны нэг үндсэн бүрэлдэхүүн нь хоршоо хэллэг болохыг тодорхойлон жишээгээр батлан гаргав. Цаашид монгол хэлний хорших ёс түүний дотор хоршоо үг, хэллэгийн талаар нэгэнт сэдэвт бүтээл гаргах цаг болсон гэдгийг судлаачид анхаарч үзэх буй за.

НОМЗҮЙ

1. Баасанбат, Д (2007) “Хөх судар” романы хоршоо үгийн хэрэглээ”, МУИС-ийн Монгол судлал эрдэм шинжилгээний бичиг”, Уб., 3-16
2. Бадамдорж, Д, (2007) “Монгол хэлний үгийн сангийн дархлаа”, [Монгол судлал сэтгүүл, 27 дугаар боть,] 18 х.
3. Базаррагчаа, М (2011) “Монгол хэлний дүрс дуурайх үг”, Уб.,
4. Базаррагчаа, М (1990) “Монгол хэлний хоршоо үгийг хэрэглэх тухайд”, Уб.,
5. Базаррагчаа, М (1993) “Монгол хэлний хоршоо үгийг ангилах нь ”, [“Монгол хэлний хоршоо үг”], Уб., 1-12 х.
6. Базаррагчаа, М (1990) “Монгол хэлний хоршоо үг авианы аргаар бүтэх нь”, [“Монгол хэлний хоршоо үг”], Уб., 80-83 х.
7. Базаррагчаа, М (1993) “Монгол хэлний хоршоо үг”, Уб.,
8. Бат-Ирээдүй, Ж (2008) “Монгол хэлний хоршоо үгийн товч толь бичиг”, Мон-Эдюкэши Пресс, Уб.,
9. Бат-Ирээдүй, Ж (2009) “Монгол хэлний хоршоо болон давтамал үг хэллэгийн сан”, Мон-Эдюкэши Пресс, Уб.,
10. Баттогтох, Д (2009) “Үгийн хоршоо”, “Үгийн ширэнгээр бэдрэхүй”, Бээжин, 34-40 х.
11. Баянсан, Ж (2002) “Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ”, Уб., “Адилтгал – ертөнцийн тухай хэлний дүр зураг”, 14-39 х.
12. Бямбадорж, Б (2006) “Орчин цагийн монгол хэлний хэлбэр судлал”, Уб., 62-68 х.
13. Дондуков, УЖ (1967) “К вопросу о парных словах в монгольских языках”, Монголын судлал, Том VI, Уб.,
14. Өнөрбаян, Ц [2006] “Орчин цагийн монгол хэлний давталтын арга, түүний үүрэг”, “Монгол судлалын чуулган”, Уб., 12-22 х.
15. Пүрэв-Очир, Б (1998) “Монгол хэлэн дэх зарим давталтын онцлог, утга, найруулгын үүрэг”, [Монгол хэлний өгүүлбэрзүй 2] Уб., 89-110 х.
16. Пүрэв-Очир, Б (2007) “Хоршоо үгийн талаар хийсэн зарим ажиглалт”, [Монгол хэлний бүтэц, утга, үүрэг, хэрэглээ 6] 75-79 х.
17. Пүрэв-Очир, Б (2007) “Монгол хэлний хорших ёсны хэв шинж, бүрэлдүүлбэрийн талаар хийсэн зарим ажиглалт”, [Монгол хэлний бүтэц, утга, үүрэг, хэрэглээ 6] 80-93 х.
18. Пүрэв-Очир, Б (2008) “Сайхан “хоршоо” найруулгын чимэг..”, [Сайн үйлсийг бүтээж салаа замаар явсан эрдэмтэн - зохиолч] 99-112 х.
19. Ринчен, (1967) “Үг хорших ёс”, [“Монгол бичгийн хэлний зүй”, Дөтгөөр дэвтэр дээд, өгүүлбэрзүй], Уб., 1-99 х.
20. Сүхбаатар, Ц (2009) “Монгол хэлний найруулгазүй”, Уб.,
21. Чимэгбаатар, Ч (1996) “Монгол холбон бэлгэлсэн үгийн товч” нэрийн зүйл, Уб.,
22. Ya.Sayinerdeni, Batuöljei, “Qorsiy-a üge”, öbör monggol-un arad-un keblel-ün qoriy-a, 1981